

## ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

**Н**ээлттэй Нийгэм Форум болон Төлсөн Авсанаа Нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвсэл хамтран Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөлд оруулах санал, зөвлөмж боловсруулах хэлэлцүүлгийг 2015 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт ТАН эвслийн гишүүн байгууллагуудаас гадна Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-ын Ажлын алба, Уул уурхайн яамны холбогдох мэргэжилтнүүд, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл зэрэг 20 гаруй хүн оролцож, хуулийн төсөлтэй холбоотой санал шүүмжлэлийг өрнүүллээ.

ОУИТБС-ын хүрээнд эрдэс баялгийн салбарын төлбөр, орлогыг ил тод болгож ирсэн сайн туршилагыг хуульчлах, цаашид 2013 онд батлагдсан ОУИТБС-ын шинэ стандартын<sup>1</sup> хэрэгжилтийг хангах замаар ил тод байдлын цар хүрээг өргөжүүлэн энэ салбарт сайн засаглалыг бэхжүүлэх зорилгоор Засгийн газраас санаачилга гарган хуулийн төсөл боловсруулж, түүнийг УИХ-ын чуулганаар хэлэлцэхээр шийдвэрлэснийг иргэний нийгмийн байгууллагууд талархан дэмжихийн сацуу хуулийн төсөлтэй холбоотой санал зөвлөмжөө ийнхүү нэгтгэн хүргүүлж байна.

Энэхүү санал, зөвлөмжийг боловсруулахдаа манай улс 2006 онд нэгдэн орж, олон улсын өмнө хэрэгжүүлэх үүрэг, амлалт авсан ОУИТБС-ын стандарттай хуулийн төслийг харьцуулан судаллаа. Түүнчлэн ОУИТБС-ыг хэрэгжүүлж ирсэн одоогийн практик, хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилттэй холбоотой тулгамдаж буй асуудлуудад анхаарал хандуулсан болно.

### Нэг. ЕРӨНХИЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

1. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд заасан эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим нь хэт явцуу хүрээнд, зөвхөн ил тод байдлыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагаанд хамаарах байдлаар тодорхойлогджээ. Хуулийн “зарчим” нь тухайн харилцааг зохицуулахад баримтлах үзэл санаа, хууль зүйн үндсэн чиглэлийг тогтоодог учраас тухайн хуулиар зохицуулах бүхий л харилцаанд нэг мөр хамаарах нийтлэг зохицуулалт байх ёстой. Иймд эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангахад баримтлах зарчмыг ОУИТБС<sup>2</sup> болон Хариуцлагатай уул уурхайн<sup>3</sup> зарчмуудтай нийцүүлэн илүү өргөн хүрээнд тодорхойлох шаардлагатай байна.
2. Хуулийн төсөлд дурдсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч”-ийн тодорхойлолт нь ОУИТБС-ын хүрээнд ил тод болгох “бенефициар өмчлөгч”-ийн ойлголтыг бүрэн илэрхийлж чадахгүй байна. ОУИТБС-ын стандартын 3 дугаар зүйлийн 3.11-д зааснаар “бенефициар өмчлөгч” гэдэг нь компанийн хувьцаа эзэмшигч төдийгүй тухайн компанийн хувьцааг шууд

1 ОУИТБС-ын зарчим, стандартыг <http://eitimongolia.mn/mn/eiti-standard> цахим хуудаснаас үзнэ үү.

2 ОУИТБС-ын зарчим, стандартыг <http://eitimongolia.mn/mn/eiti-standard> цахим хуудаснаас үзнэ үү.

3 Хариуцлагатай уул уурхайн 8 зарчим: 1. Олон талын оролцоог хангах 2. Ил тод нээлттэй байх 3. Хуулийг сахин дээдлэх 4. Байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх 5. Ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах 6. Үр өгөөжтэй байх 7. Хүмүүнлэг ёс зүйтэй байх 8. Дэвшилтэт технологид суурилсан байх.

эзэмшдэггүй боловч ямар нэг хэлбэрээр, шууд бус байдлаар ашиг хүртдэг, компанийг удирддаг, хянадаг, шийдвэр гаргахад нөлөөлөх эрх мэдэл бүхий бүх этгээдийг хамарсан өргөн хүрээтэй ойлголт юм.

Тиймээс “бенефициар өмчлөгч”-ийн тухай ойлголтыг ОУИТБС-ын стандартад нийцүүлэн тодорхойлж, хуулийн төслийн нэр томъёоны хэсэгт тусган, холбогдох мэдээллийг нийтэд ил тод болгох зохицуулалтыг хуулиар тогтоох нь зүйтэй.

3. Хуулийн төсөлд “оператор” болон “туслан гүйцэтгэгч” компаниуд ил тод байдлын анхан шатны тайлан гаргах зохицуулалтыг тусгажээ. Уул уурхайн төсөлд бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх үйл ажиллагаа нь маш олон төрөл, чиглэлтэй учир энэхүү хуулийн үйлчлэлд хамаарч ил тод байдлын тайлан гаргах “оператор” болон “туслан гүйцэтгэгч”-ийг ялган тодорхойлох шаардлагатай байна. Уул уурхайн үйл ажиллагааг дагалдах олон төрлийн бизнесээс зөвхөн эрдэс баялгийг эрэх, хайх, ашиглах, боловсруулах, байгаль орчныг нөхөн сэргээх, дэд бүтэц байгуулах зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн үйл ажиллагааг гэрээгээр хэрэгжүүлж буй “туслан гүйцэтгэгч”, “оператор” компаниуд л ил тод байдлын тайлан гаргах шаардлагатай юм. Иймд Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн хүрээнд ил тод байдлын тайлан гаргах “туслан гүйцэтгэгч”, “оператор компани”-ий тодорхойлолтыг хуулийн төслийн нэр томъёоны хэсэгт тусгах нь зүйтэй юм.
4. Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллага нь зөвхөн Үндэсний зөвлөл, түүний Ажлын алба байна хэмээн тусгасан нь ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй одоогийн тогтолцоо, практикийг бүрэн илэрхийлж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл Үндэсний зөвлөлийн чөлөөт цагт ажиллах Ажлын хэсэг, орон нутагт санаачилгыг хэрэгжүүлэх дэд зөвлөл зэрэг бүтцийг орхигдуулжээ. Иймд дараах бүтэц, бүрэлдэхүүнийг хуулийн төсөлд тусгахыг санал болгож байна. Үүнд:
  - Эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөлөөс гадна түүний чөлөөт цагт ажиллах Ажлын хэсэг, аймаг, нийслэлийн дэд зөвлөл, сум, дүүргийн салбар зөвлөлийн эрх үүргийг хуульчлах шаардлагатай. ОУИТБС-ыг хэрэгжүүлж буй одоогийн туршлагаас харахад Ерөнхий сайдаар ахлуулсан, холбогдох яам, агентлагийн удирдах албан тушаалтнуудаас бүрдсэн Үндэсний зөвлөл нь тогтмол хуралддаггүй, хуралдсан ч Үндэсний зөвлөлийн гишүүд болох төрийн өндөр албан тушаалтнууд хуралд тэр бүр биечлэн оролцдоггүй, гишүүдийн тоо хязгаартай тул санаачилгын хэрэгжилтэд оролцдог төрийн бүх байгууллагын төлөөллийг хангах боломжгүй байдаг. Иймд Үндэсний зөвлөлийн чөлөөт цагт ажиллах, 3 талын тэгш оролцоо, тэр дундаа холбогдох төрийн байгууллагын гүйцэтгэх албан тушаалтнуудын оролцоог хангасан Ажлын хэсэг байгуулах зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, эрх үүргийг ОУИТБС-ын стандартын 1-р шаардлагад нийцүүлэн Засгийн газрын 2012 оны “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 222 дугаар тогтоол болон 2012 оны “Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай” 62 дугаар тогтоолд заасан журмыг тус тус харгалзан тодорхойлох нь зүйтэй юм.
  - Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг орон нутагт хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж буй орон нутгийн дэд, салбар зөвлөлийг Үндэсний зөвлөлөөс байгуулж, бүрэн эрх, чиг үүргийг Үндэсний зөвлөлөөс баталсан журмаар зохицуулах заалтыг хуульд тусгах нь зүйтэй.
  - Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ордоггүй, анхан шатны тайлан гаргадаггүй боловч эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хэрэгжүүлэхэд тодорхой үүрэгтэйгээр оролцдог Авлигатай тэмцэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газар гэх мэт төрийн байгууллагын эрх, үүргийг хуулиар тодорхойлох нь зүйтэй.
  - ОУИТБС-ын нэг үндсэн тал болох иргэний нийгмийн оролцоо, эрх, үүргийг хуулиар баталгаажуулах шаардлагатай. ОУИТБС-ын хэрэгжилтэд оролцогч иргэний нийгмийн байгууллагуудад ил тод байдлын тайлан гаргах үүргийг оногдуулах тохиолдолд зөвхөн уул уурхайн компаниас авсан, хандив, дэмжлэг, тэдгээртэй байгуулсан гэрээг тайлагнах үүргийг оногдуулж болох юм.

5. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.5.7, 11.5.9, 11.5.10-т “нийгмийн хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, хандив, тусламж” зэрэг ойлголттой холбоотой зохицуулалтыг тусгасан байна. Гэхдээ дээрх ойлголтыг нэг мөр тодорхойлж өгөөгүй нь хуулийг хэрэгжүүлэхэд эргэлзээ үүсгэх, өөр өөрөөр тайлбарлаж хэрэглэх эрсдэлийг үүсгэхээр байна. Иймд дээрх нэр томъёог хэрхэн ойлгохыг нэг мөр тодорхойлон хуулийн төслийн нэр томъёоны хэсэгт тусгах нь зүйтэй юм.
6. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.5.10-т заасан “орон нутгийн байгууллага” гэдэгт нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын алийг хамааруулж ойлгохыг тодорхой хуульчлах шаардлагатай байна.
7. ОУИТБС-ын 3.12 дугаар шаардлагыг хангах үүднээс Засгийн газрын зүгээс ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлох асуудлаар аливаа хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, түүний хавсралт, нэмэлт өөрчлөлт, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг ил тод болгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй.
8. Хуулийн төслийн 12 дугаар зүйлд заасан төрийн байгууллагын ил тод байдлын анхан шатны тайланд тусгах мэдээллийг ОУИТБС-ын шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх нь зүйтэй. Ингэхдээ уул уурхайн салбарын орлогыг эрдсийн төрөл тус бүрээр буюу газрын тос, нүүрс, алт гэх зэргээр ангиан тайлагнах зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй.
9. Хуулийн төсөлд тайлан гаргагч байгууллагын эрх, үүрэг, хариуцлагаас гадна ил тод байдлын анхан шатны болон нэгтгэл тайлан гаргах процессыг тусгах нь зүйтэй байна.
10. Хуулийн төслийн 13 дугаар зүйлд “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын нэгдсэн тайлан” нь зөвхөн статистик буюу тоон мэдээ бүхий тайлан байхаар тусгасан нь ОУИТБС-ын стандартад нийцэхгүй байна. Тиймээс ОУИТБС-ын 3-р шаардлагын дагуу салбарын тойм мэдээлэл, бодлого, эрх зүйн орчин, орон нутагт шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг тооцох аргачлал, экспорт, өндөр үнийн дүн бүхий ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа, түүний зардал, ажлын байр, салбарын тулгамдсан асуудал зэрэг үндсэн мэдээллийг агуулсан тайланг тусад нь гаргадаг байх зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй.
11. Уул уурхайн салбараас орсон төсвийн орлогын тодорхой хувийг уг салбарыг ил тод, хариуцлагатай болгоход зориулах ёстой. Үүний тулд тусгай сан байгуулах, эсвэл Төсвийн тухай хуульд заасан одоогийн тогтолцоонд нийцсэн тодорхой зохицуулалтыг хуульд тусгах замаар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох шаардлагатай байна.
12. Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1-т “зөрчил гаргасан этгээдэд Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн шүүгч захиргааны шийтгэл ногдуулах тухай” заасан нь өнөөгийн шүүхийн тогтолцоо болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай нийцэхгүй байна. Түүнчлэн Үндэсний зөвлөл нь улиралд нэг удаа хуралдахаар хуулийн төсөлд тусгасан тул захиргааны зөрчилд хариуцлага тооцох хөөн хэлэлцэх хугацаа дуусах зэрэг байдлууд үүсэх тул хуулийн төслийн энэ заалтыг шүүхийн тогтолцоо, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамд нийцүүлэн өөрчлөх нь зүйтэй.
13. Анхан шатны тайлан гаргах үүргээ зөрчсөн тусгай зөвшөөрөл эзэмшигч, оператор, туслан гүйцэтгэгч болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох нөхөрлөлд оногдуулах хариуцлагыг ялгаатай хуульчлах шаардлагатай. Ингэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчид оногдуулах хариуцлагыг нэмэгдүүлж, тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл хариуцлага тооцох зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй.
14. Ил тод байдлын “нэгдсэн тайлан” нь ОУИТБС-ын үр дүнг илтгэх үндсэн баримт бичиг юм. Иймд тайлан нэгтгэгч этгээд, түүнд тавигдах шаардлага, сонгон шалгаруулах журам, эрх үүрэг, хариуцлагыг хуульд тодорхой тусгах шаардлагатай байна.

## Хоёр. ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

Д/Д	ХУУЛИЙН ТӨСӨЛД ЗҮЙЛ, ЗААЛТ НЭМЭХ	ҮНДЭСЛЭЛ
1.	2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтын “...Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” гэсний дараа “Шилэн дансны тухай хууль” гэж нэмэх	Энэ хуулийн хүрээнд ил тод болгох зарим мэдээлэл, ялангуяа төрийн өмчит уул уурхайн компаниудын байгуулсан концессын болон бусад гэрээ хэлцэл нь Шилэн дансны хуулийн зохицуулалтад хамаарах юм.
2.	3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын “... тэдгээрт үндэслэн эрдэс баялгийн салбарын ил тод” гэсний дараа “байдлыг хэрэгжүүлэх” гэж нэмэх	Хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх
3.	3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт” гэсэн 5 дугаар зүйлд нэгтгэх	3.2 дахь заалт нь “ашигт малтмал” гэсэн нэр томъёог тодорхойлсон тул нэр томъёоны хэсэгт оруулах нь зүйтэй.
4.	5 дугаар зүйлд “туслан гүйцэтгэгч”, “бенефициар өмчлөгч”, “оператор компани” гэсэн ойлголтуудын тодорхойлолтыг нэмэх	Хуулийн төсөлд “туслан гүйцэтгэгч”, “бенефициар өмчлөгч”, “оператор компани”-тай холбоотой тодорхой зохицуулалтууд орсон учир эдгээр ойлголтыг нэг мөр тодорхойлох шаардлагатай.
5.	5 дугаар зүйлд “нийгмийн хөрөнгө оруулалт” гэсэн ойлголтын тодорхойлолтыг тусгах	Одоогийн практикт ОУИТБС-ын тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төрийн байгууллага, орон нутаг, ТББ, иргэдэд өгсөн хандив тусламжийг нийгмийн шинжтэй хөрөнгө оруулалт гэж үзэн мөнгөн болон мөнгөн бус хандив гэсэн ангиллаар тайлагнадаг. Гэтэл хуулийн төслийн 11.5.11-д төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн хандив, тусламжийн талаарх мэдээлэл, түүний хэмжээг тусад нь тайлагнахаар заасан байх тул нийгмийн хөрөнгө оруулалтыг хандив тусламжаас ялган тодорхойлох шаардлагатай юм.
6.	9 дүгээр зүйлийн 9.1.8-д “Ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлох эрх олгох болон бусад гэрээг хуулийн этгээд, иргэнтэй байгуулсан төрийн байгууллага нь уг гэрээ, түүний хавсралт, нэмэлт өөрчлөлт, тэдгээрийн үндсэн нөхцлийг гэрээ байгуулснаас хойш, эсвэл гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаас хойш ажлын 5 хоногийн дотор цахим хуудсанд байршуулж, нийтэд ил тод болгох” гэж нэмэх	ОУИТБС-ын гэрээний ил тод байдлын талаарх 3.12 дугаар шаардлагыг хангах
7.	11 дүгээр зүйлийн 11.5.5-д “хөрөнгө оруулалтын зардал” гэж нэмэх	Одоогийн практикт тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хөрөнгө оруулалтын зардлыг сайн дурын үндсэн дээр тайлагнаж байгаа тул нэгэнт тайлагнаж хэвшсэн энэхүү мэдээллийг хуулийн төсөлд тусган баталгаажуулах нь зүйтэй.
8.	11 дүгээр зүйлийн 11.5 дахь заалтад “төрийн өмчит аж ахуйн нэгжид төлсөн төлбөр, төрийн өмчит аж ахуйн нэгж хооронд хийгдсэн материаллаг төлбөр” гэж нэмэх	ОУИТБС-ын 4 дүгээр шаардлагын 4.2.в шаардлагыг хангах
9.	11 дүгээр зүйлийн 11.10 дахь заалтад “төрийн байгууллага” гэж нэмэх	ОУИТБС-ын шаардлагын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн анхан шатны тайланд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төрийн байгууллагад өгсөн хандив, тусламжийг тусгах ёстой.

10.	12 дугаар зүйлийн 12.6-д “тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний туслан гүйцэтгэгчээс хүлээн авсан хандив, тусламж зэрэг татварын бус төлбөрийн талаарх мэдээлэл” гэж нэмэх	ОУИТБС-ын хүрээнд төрийн байгууллага хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус хандив, тусламжийг тайлагнаж байгаа практикийг хуульчлах
11.	13 дугаар зүйлийн 13.6.8-д “төрийн байгууллага” гэж нэмэх	
12.	13 дугаар зүйлийн 13.6.2-т “эрдэс баялгийн салбарын нийт орлогод ашигт малтмалын төрөл, орлогын төрөл тус бүрийн эзлэх хувь хэмжээ” гэж нэмэх	ОУИТБС-ын 4.1 дүгээр шаардлагыг хангах
13.	16 дугаар зүйлд “хуулийн этгээдийн анхан шатны тайлан гаргах үүрэг бүхий этгээд нь энэ хуулийн 14 дүгээр зүйлийг зөрчсөн бол тусгай зөвшөөрөл эзэмшигч болон оператор, туслан гүйцэтгэгч хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ... дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа нөхөрлөлийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ... дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ... дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох” гэж нэмэх	Зөрчлийн шинж чанараас хамааран анхан шатны тайлан гаргах болон зөрүүг тайлбарлах нэмэлт материал, мэдээлэл ирүүлэх үүргийн зөрчилд оногдуулах хариуцлага ялгаатай байх шаардлагатай.
14.	16 дугаар зүйлд “энэ хуулийн дагуу захиргааны хариуцлага оногдуулсан нь анхан шатны тайлан гаргах үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж нэмэх	Анхан шатны тайлан гаргах үүргийн хэрэгжилтийг захиргааны шийтгэл оногдуулсан эсэхээс үл хамааран хангуулах
<b>ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ЗҮЙЛ, ЗААЛТ ХАСАХ</b>		<b>ҮНДЭСЛЭЛ</b>
15.	6 дугаар зүйлийн 6.12-т “Монгол Улсын Ерөнхий сайдаас бусад Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд орох төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байна” гэсэн заасныг хасах	Иргэний нийгмийн эвсэл өөрсдийн дотоод журмаар 2 жил тутамд Үндэсний зөвлөл дэх төлөөллөө өөрчилдөг ба төрийн улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаа 4 жил байдаг. Иймд Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацааг хуульд 3 жилээр хатуу тогтоох боломжгүй юм.
16.	11 дүгээр зүйлийн 11.5.3-т “тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг тайланд тусгана” гэж заасныг хасах	Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг Ашигт малтмалын газрын тусгай зөвшөөрлийн бүртгэлийн мэдээлэлд тулгуурлан Тайлан нэгтгэгч бэлтгэн гаргадаг тул энэ мэдээллийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн анхан шатны тайланд тусгах шаардлагагүй болно.
17.	13 дугаар зүйлийн 13.6.9-д “Төрийн байгууллагаас төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн ажил, үйлчилгээний төлбөрийн дүн” гэж заасныг хасах	Энэ хууль нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах, тэр дундаа төрийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хооронд хийгдсэн төлбөр, орлогыг ил тод болгох зорилготой тул төрийн байгууллагаас эрдэс баялгийн үйл ажиллагаа эрхэлдэггүй субъект болох төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн ажил үйлчилгээний дүнг тайлагнах шаардлагагүй юм.
18.	12 дугаар зүйлийн 12.6.10-д “Төрийн бус байгууллага, орон нутгийн байгууллага, иргэнд өгсөн ажил, үйлчилгээний төлбөрийн дүн” гэж заасныг хасах	



ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫГ ӨӨРЧЛӨН НАЙРУУЛАХ		ҮНДЭСЛЭЛ
19.	5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтын "... даасан үйл ажиллагаа" гэснийг "даан ..." гэж өөрчлөх	Найруулгын алдааг залруулсан
20.	6 дугаар зүйлийн 6.3-т "Үндэсний зөвлөлийн хуралдаан нь нийт төлөөлөгчдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно" гэснийг "Үндэсний зөвлөлийн хуралдаан нь оролцогч тал тус бүрийн гуравны нэгээс доошгүй төлөөлөгч оролцсоноор хүчин төгөлдөр болно" гэж өөрчлөх	Иргэний нийгэм, компани, төрийн төлөөлөл нь тус бүрдээ Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгийг бүрдүүлдэг. Ийм нөхцөлд хурлын төлөөлөгчдийн олонх оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болох шалгуур тогтоосон нь дээрх талуудын аль нэг нь бүхэлдээ хуралдаанд оролцоогүй тохиолдолд ч хуралдаан хүчин төгөлдөр байх боломжийг бүрдүүлж байна. Иймд шийдвэр гаргах үйл явц дахь талуудын оролцоог баталгаажуулах зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй.
21.	11 дүгээр зүйлийн 11.5.9-д заасан "ажлын байрны мэдээлэл" гэснийг "гадаадын болон Монгол Улсын иргэдийн ажлын байрны тоо, орон нутгийн иргэдийн ажлын байрны тоо" гэж өөрчлөх	Тайланд гадаад болон дотоод ажилчдын тоо, тэр дундаа орон нутгаас ажил эрхэлж байгаа хүмүүсийн тоог тусгах нь зүйтэй.
22.	Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.6.3-т "олгосон тусгай зөвшөөрлийн" гэдгийг "тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны" гэж өөрчлөх	ОУИТБС-ын 3.9-3.10 дугаар шаардлагыг хангах
23.	Хоёр дугаар бүлгийн нэрийг "Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хэрэгжүүлэх тогтолцоо" гэж өөрчлөх	Энэ бүлэг нь зөвхөн холбогдох байгууллагын эрх үүргийг тогтоох бус, харин Эрдэс баялгийн ил тод байдлыг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоог бүхэлд нь зохицуулж байна.
24.	16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг "анхан шатны тайлан гаргах үүрэг бүхий хуулийн этгээд нь энэ хуулийн 11-р зүйлд заасан үүргээ биелүүлээгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг цуцлах, оператор, туслан гүйцэтгэгч хуулийн этгээд, бичил уурхайгаар ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа нөхөрлөлийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тус тус торгох" гэж өөрчлөх	Сүүлийн жилүүдэд ОУИТБС-ын тайлан гаргах аж ахуйн нэгжийн тоо буурч байгаа тул тайлан гаргах үүргийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай. Жишээ нь, 2013 онд тайлан гаргагч компанийн тоо өмнөх оныхоос 329-өөр буурсан бол, 2015 оны 10 сарын 15-ны өдөр буюу Нэгтгэл тайлан гаргах ажил ид өрнөж байгаа үед нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 43 хувь нь анхан шатны тайлангаа гаргаагүй байгаа талаар Ажлын албанаас мэдээлжээ. <sup>4</sup>

4 <http://citimongolia.mn/mn/node/4873>

Дугаарыг эрхэлсэн: Д.Эрдэнэчимэг, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

Дугаарт оролцсон: Ж.Даваасүрэн, Хуульч

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1  
Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 14240  
Монгол Улс

Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: [www.forum.mn](http://www.forum.mn)  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)